

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-21
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	6
2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	6-9
3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	9-16
4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	16-21

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 06-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 13 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батжаргал, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Л.Мөнхбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Одонтуяа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд үг хэлэв.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 09 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, мөн хэлтсийн дотоодын зөвлөх Д.Номингэрэл, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Г.Амартүвшин нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Ш.Раднаасэд нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: 1.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.2.хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмэх:

“36.4.Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “, хөндлөнгийн” гэснийг хасаж, мөн зүйлийн 50.5, 50.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, үүнтэй уялдуулан 50.7, 50.8 дахь хэсгийг хасах:

“50.5.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.

50.6.Үнэлгээний хороонд тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ц.Сандаг-Очир, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 03 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 10 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон
“Жанжин Д.Сүхбаатар” танхим
09 цаг 13 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 06
ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР
МЯГМАР ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

Та бүхэнд хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Хавдисламын Баделхан, Жамбын Батсуурь, Болдын Жавхлан, Цэндийн Сандаг-Очир, Дуламдоржийн Тогтохсүрэн, Чимэдийн Хүрэлбаатар, Баттогтохын Чойжилсүрэн.

Ингээд нийт 10 гишүүн хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

Ингээд 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаан нээсэн тул та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

2-т, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

3-д, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

4-д, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх асуудлууд байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой санал байна уу? Алга. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Би энэ өнгөрсөн жил нэг хуулийн төсөл өгчихсөн байгаа юм. Их Хурлын дарга дээр байгаа байх. Тэмүүлэн даргад би бас хэлж байсан юм. Энэ төрийн өмчит усан цахилгаан станцуудын үл хөдлөхийн албан татвараас чөлөөлөх тухай гээд нэг төсөл бэлэн байгаа. Тэр нь ямар зориулалт, зорилготой юм гэхээр одоо нийтдээ улирлын чанартай ажилладаг Говь-Алтай, Алтай, Улиастай дээр 2, байнга ажиллаж байгаа 1, Тайшир Алтай УЦС, Богдын гол, Гуулин, Алтай, Гуулин, Тайшир гээд үүний үл хөдлөхийн татвар гээд ингээд татвар авдаг. Татвар авахдаа зүгээр байшин барилгын татвар биш Усан цахилгаан станцын объектоор нь татварыг тогтоочихсон. Тэгээд жил болгон татвар нь нэмэгдээд өр нь нэмэгддэг. Тэгээд нөгөө татварын байгууллагууд шүүхэд хандаад шүүхийн шийдвэрээр бүх дансуудыг нь битүүмжилчихсэн. Үүнийг нь татвараас чөлөөлье гэсэн нэг төсөл бэлэн байгаа юм. Үүнийг энэ юутай нь хамт, одоо бол яах вэ өнөөдөр орж амжихгүй л байх.

Энэ эрчим хүчний гааль тарифын гаалийн татварын хуульд өөрчлөлт хийж байгаа энэ юмнууд дээр хамтад нь хэлэлцээд явчих юмыг даргын зөвлөл дээр нэг яриаг. Төсөл нь бол өргөн баригдаад Их Хурлын дарга дээр байж байгаа. Ийм л нэг ийм горимын гэх юм уу нэг ийм санал гэх юм уу нэг ийм юм байгаа. Одоо Дөргөн орно, аягүйдвэл. Эрдэнэбүрэн, Эрдэнэбүрэн орно. Дахиад л яг энэ асуудал дахиад гарч ирэх байх. Өөрөө үйлдвэрлэл ашигтай байдаг. Тэгээд тариф

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тогтоочихсон, үйлдвэрлэж байгаагаас нь хүчин чадлаас өртгөөс нь илүү бага тарифтайгаар эрчим хүчээ нийлүүлдэг. Тэгсэн мөртөө татвараа авдаг, татвар нь авахдаа зүгээр нэг байшин барилга, оффисын барилга биш байгууламжаар нь аваачаад татвар тогтоогоод хаячихсан. Тэгээд түүнийг чинь ерөөсөө даах аргагүй байгаа байхгүй юу. Усан цахилгаан станцын байгууламж гэхээр тэр чинь бараг нуур нь тэр чигтээ орчих гээд байгаа.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний саналыг сонслоо. Энэ асуудлыг судлаад эргээд даргын зөвлөлөөр дараагийн Байнгын хорооны хурал дээр ирээд хариу мэдэгдье, танд.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. 1 дэх асуудал.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын хэлтэс чуулганы 6 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай Улсын Их Хурлын даргын 2023 оны 96 дугаар захирамж гарсан. Ингээд захирамжийн дагуу Байнгын хорооны цаглаварын төслийг бас хэлэлцэхээр заасан байгаа. Та бүхэнд бас цаглаварын төслийг тараасан. Байнгын хорооны цаглавартай холбогдуулаад асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ингээд “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ирц чуулганы 6 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх

асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёолоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

10 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжин, 80 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

09.11 цаг

2 дахь асуудал.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

3.Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Ц.Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга, Г.Гийхнаран Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга, Д.Номингэрэл Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дотоодын зөвлөх гэсэн байна.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Баделхан гишүүн. Баделхан гишүүний микрофоныг өгье.

Х.Баделхан: Баярлалаа. Энэ зарчмын зөрөөтэй санал дээр үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн нь иргэдийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн гэж ингээд нөгөө үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох хүмүүсийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар ишийдэхээр болж байгаа юм уу? Энэ чинь арай бүр хүнд сурталтай болоод байгаа юм биш үү? Бүр энэ байвал ер нь бүр цаашдаа ажил явахад бүр хүндрэлтэй болох юм биш үү, ер нь. Нэг ёсондоо үнэлгээний хорооны хараат бус гишүүнийг иргэдийн төлөөллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилохоор болж байх шиг байна л даа. Энэ арай хүнд сурталтай байгаа юм байна. Энэ дээр тодруулга авмаар байна.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга хариулах уу? Батзул. Энхболд дарга хариулах уу? 4 номер.

Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд Баделхан гишүүний асуултад хариулъя. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн заалт нь бас мөн ийм байгаа. Иргэнийг сонгохдоо энэ худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн сертификаттай ийм хүний бүртгэлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр бий болгоод үүнээсээ нэг иргэнийг сонгож оролцуулна гэсэн ийм байгаа. Тэгээд үнэлгээний хорооны үйл ажиллагааны ажиллах журам дээрээ энэ асуудлуудыг нарийвчлаад тэр хүндрэл чирэгдэлгүй байх асуудлыг нь нарийвчлаад зохицуулаад явах бололцоотой гэж үзэж байгаа. Одоо бол ямар нэг хүндрэл чирэгдэл гарахгүйгээр явж болж байгаа. Тийм.

Г.Тэмүүлэн: Баделхан гишүүн нэмж тодруулах уу, зүгээр үү. Нэмж тодруулах уу? нэмж тодруулъя.

Х.Баделхан: Тэгэхээр энэ иргэдийн төлөөллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар ердөө 1 удаа ингээд жагсаалтыг нь баталчих юм уу? Жилд нэг удаа эсвэл нөгөө тендер зарласан болгонд л төлөөлөлгүй байвал тэр чинь иргэдийн хурал хуралдахгүй шүү дээ. Бас нэлээн хүнд сурталтай болно л

доо. Үүнийг бол яг амьдрал дээр яаж зохицуулж байгаа юм бол?

Г.Тэмүүлэн: Энхболд дарга асуултад хариулъя, 4 номер.

З.Энхболд: Сангийн сайдын тушаалаар энэ асуудлыг нарийвчлаад зохицуулж байгаа. Одоо ч мөн үүнийг ингээд зохицуулагдаад явж байгаа. Үүн дээр бол ямар нэгэн хүндрэл чирэгдэл гарахгүй байгаа. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрөө нэг үнэлгээний хороо нь байгуулагдахад түүнд нэг иргэн санал болгох тухай бүрдээ хуралдах шаардлагагүй. Тухайн сум болон аймагт тухайн чиглэлээр мэргэшсэн бүртгэлийг бол Сангийн сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу нэг удаа бүртгэчихнэ. Тэндээсээ тэгээд сонгоод яваад байх бололцоотой.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн асуулт асууя.

Ш.Раднаасэд: Энэ нөгөө эм, эмнэлгийн хэрэгсэл чинь хамгийн өндөр оноотой тендерийг сайн ингээд үзнэ гэгчихсэн байх юм. Нөгөө чанар юугаар нь ангилна гэдгээ хаанаа биччихсэн юм. Нөгөө чанар нь 70 хувь, үнийн санал нь 40 хувь байна, 30 хувь байна гэдэг нь. Энэ чинь төсөл дээр 2 дахь хэлэлцүүлгээр ороход тараагдсан байсан шүү дээ. Тэр чинь алга болчихсон байна шүү дээ. Тэгээд энэ санал хураагдаад дэмжигдсэн юмыг ингээд дураараа засчхаж болох юм уу? Ерөөсөө би хайгаад олдоггүй. Энэ 27.6 дээр энэ чинь арай өөрөөр бичигдсэн байх юм.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга Сандаг-Очир дарга асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир: Раднаасэд гишүүн танд тараагдсан хуулийн төсөл анх өргөн баригдсан хуулийн төсөл байгаа. Тэгээд эцсийн хэлэлцүүлгээр энэ саналууд хураагдаад тэгсний дараа шигтгэж орж ирнэ, тийм. Одоо зарчмын зөрөөтэй 3 санал байгаа. Нэг дэх санал нь

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

энэ ерөөсөө хураагдчихсан саналууд байгаа. Энэ чинь нөгөө хурлын тухайн үед хурлын даргыг даргалж байсан Мөнхбаатар дарга, Даваасүрэн гишүүн болоод Батлут гишүүдийн гаргасан санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгчихсөн байгаа юм. Тэгээд үлдсэн 3 санал байгаа, түүнээс өмнөх 2 нэлээн хэдэн саналууд 30, 40 санал хураагдчихсан шүү дээ. Тэр саналууд дотор явж байгаа. Энэ ингээд үргэлжлэл нь явж байгаа, өмнөх зарчмын зөрөөтэй саналын чинь. Тэгээд энэ саналууд эцэслэн хураагдаж дуусаад тэгээд төсөл дээрээ шигтгэгдэж орж ирнэ гэсэн үг. Түүнээс өөрчлөгдөөгүй шүү.

Г.Тэмүүлэн: Болсон уу, Раднаасэд гишүүн.

Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс 3 зарчмын зөрөөтэй саналын томъёолол ирүүлсэн байгаа. Ажлын хэсгээс ирүүлсэн зарчмын зөрөөтэй саналуудаар санал хураалтыг явуулъя.

1 дүгээрх нь, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.2.хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах бол;” Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Асуулттай гишүүд байна уу? Байхгүй. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжин 69.2 хувиар дэмжлээ.

2.Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмэх:

“36.4.Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу худалдан авах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжлээ. 69.2 хувиар дэмжлээ.

3.Төслийн 50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсгийн “, хөндлөнгийн” гэснийг хасаж, мөн зүйлийн 50.5, 50.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, үүнтэй уялдуулан 50.7, 50.8 дахь хэсгийг хасах:

“50.5.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг сонгоно.

50.6.Үнэлгээний хороонд тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулж болно.” Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт.

Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжлээ. 69.2 хувиар дэмжлээ.

Ингээд санал хураагаад яваад дуусчихсан даа, дууссан даа. Та чуулган дээр нэмж тодруулах уу.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир нэгдсэн хуралдаанд танилцуулна.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ингээд хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

09.30 цаг

Дараагийн асуудал.

3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн танилцуулна. Чойжилсүрэн гишүүний микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Байнгын хорооны дарга, гишүүд ээ, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Шинэ сэргэлтийн бодлогод туссан эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх аймаг, орон нутагт үйлдвэрлэл технологийн парк байгуулах, Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлж ажлын байр бий болгох, цаашлаад хот, суурин газарт шинэ суурилын бүсүүдийг бий болгоход эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж хуучин хүчин чадалыг өргөтгөх, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх зайлиггүй шаардлагатай байна.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 7-8 хувиар өсөж, эрчим хүчний салбар системийн нийт суурилагдсан хүчин чадалыг бүрэн ашиглаж, импортын эрчим хүчний дэмжлэгтэйгээр өвлийн оргил ачааллыг давж байна.

Шинэ сэргэлтийн бодлогод хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 450 мвт хүчин чадал бүхий Тавантолгойн цахилгаан станц, 400 мвт хүчин чадал бүхий

Багануурын цахилгаан станц, 300 мвт хүчин чадал бүхий Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг барьж байгуулах мөн Дулааны 3 дугаар цахилгаан станцыг 300 мвт-аар өргөтгөх төслүүдийг төлөвлөсөн.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай 2015 оны Парисын хэлэлцээрийн дагуу олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас нүүрсний эрчим хүчний эх үүсвэрт олгох санхүүжилт хумигдсан. Мөн БНХАУ-ын Засгийн газар хилийн чанадад нүүрсний эрчим хүчний шинэ эх үүсвэр барих, санхүүжүүлэхээс татгалзах бодлогыг 2021 оны 9 дүгээр сард илэрхийлсэн. Монгол Улсын эрчим хүчний анхдагч нөөц баялагтаа тулгуурлан суурь ачааллын горимд ажиллах том чадлын ДЦС барих зайлиггүй шаардлагатай боловч санхүүгийн эх үүсвэрийн хязгаарлалт, олон улсын худалдаа бизнест тулгарч буй цар тахлын нөлөө, үнийн өсөлт зэрэг шалтгааны улмаас эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт татахад хүндрэлтэй болж байна.

Иймд нүүрсээр ажиллах ДЦС барих болон өргөтгөх төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд үндсэн тоног төхөөрөмжийг импортоор худалдаж авах болон дотоодод үйлдвэрлэхэд тодорхой хугацаанд татварын дэмжлэг үзүүлэх хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьж байна. Тухайлбал цахилгаан эрчим хүчний 5 мвт-аас дээш хүчин чадалтай дулааны эрчим хүчний, 1,5 мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэр барих, суурилагдсан хүчин чадалыг өргөтгөх, тухайн шинэ эх үүсвэрийг цахилгаан, дулааны хангамжийн системд холбох шугам болон дагалдах дэд бүтцийн төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг импортын нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эс үгүй

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бол уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх. Эдгээр тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.

Түүнчлэн цахилгаан эрчим хүчний 5 мвт-аас дээш хүчин чадалтай, дулааны эрчим хүчний 1,5 мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг 90 хувь хөнгөлөх зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд тусгасан болно.

Эрчим хүчний нэгдсэн системд тогтвортой үйл ажиллагаатай том чадлын станцууд холбогдсоноор сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг холбох техникийн боломж бүрдэж, системийн оновчтой бүтэц бий болгох ач холбогдолтой юм. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх хугацааг цахилгаан станцын барилга угсралтын ажил үргэлжлэх хугацаатай уялдуулан 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байхаар хуулийн төслүүдэд тусгасан.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайдад баярлалаа.

Та бүхэнд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сангийн сайд Жавхлан, Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын

дарга Ерэн-Өлзий, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Мөнх-Оргил, Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга Мөнхжаргал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Өнөрболор гишүүнээр тасалъя. Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Сайн байцаана уу? Энэ өглөөний мэндийг хүргэе. Би нэг энэ асуултаа асуухаас өмнө нэг зүйл асуух гэсэн юм. Өөрөөр хэлэх юм бол энэ дулааны эх үүсвэрийн 1,5 мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэр гээд тэгж байна шүү дээ, тийм ээ. Тэгэхээр энэ уурын зуух дулааны юу нүүрсний уурын зуухнууд орох уу?

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Өнөрболор гишүүн асуултад хариулъя. Энэ 1,5 мвт-аас дээш хүчин чадалтай уурын зуух бол орно. Уурын зуух бүр бас янз бүрийн хүчин чадалтай байгаа. 1,5 гэдэг тоог яагаад тавьсан юм бэ гэхээр багасгаж болох юм. Тэгэхээр айл өрх болгоны дулааны эх үүсвэрүүдийг чөлөөлөөд эхэлчих юм бол нөгөө утаа гэдэг асуудал байгаа учраас аль болох тэнд жоохон цуглуулах бодлого бариад байгаа юм. Айлууд уурын зуухнууд нийлээд 1,5 мвт-аас дээшээ байхгүй бол айл болгон, өрх болгон утаа үйлдвэрлээд байгаа учраас ингээд энэ 1,5 мвт гэдэг босго тавьчихсан юм.

Уурын зуух шаардлагатай үед барина шүү дээ. Шаардлагатай бол хотын захгаар барина шүү дээ. Ондoo арга байхгүй. Шүүлтүүр тавиад барина. Орчин үеийн уурын зуухнууд бүрэн шаталттай болчихсон байгаа.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулах уу? Өнөрболор гишүүн.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Д.Өнөрболор: Тэгээд хуучин чинь тэр нөгөө агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдэд энэ уурын зуухыг барихыг бас хориглоод, хязгаарлаад тэгээд энэ хотод баригдаж байсан уурын зуухнуудыг бүгдийг нь татан буулгах ийм ажиллагаа явагдсан шүү дээ. Одоо тэгээд энэ хэдий технологийн хувьд бас ингээд тодорхой шийдэлтэй байгаа хэдий ч гэсэн уурын зуух барина гэдэг нь нэг л ойлгомжгүй болоод явчихлаа. Тэгээд энэ ер нь энэ эрчим хүчний хэрэглээ ер нь импортоос ингээд хамааралтай байгаад байгаа шүү дээ. Тэгээд найдвартай хангамж ч гэсэн үндсэндээ алдагдсан байгаа. Үнийн энэ тарифын зохистой тогтолцоогүй байгаа.

Тэгээд энэ салбарын хэмжээнд санхүүгийн тогтворгүй байдал үнэхээр үүссэн гэдгийг бид нар мэдэж байгаа. Тэгээд энэ эрчим хүч үйлдвэрлэх төрийн өмчийн компаниудын алдагдал ер нь жилд дунджаар 36 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 22 онд бол 168 ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмээд тодруулаад асууцих, гүйцээгээд. Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: 22 онд 168.2 тэрбум төгрөгт хүрсэн байгаа юм байна. Тэгээд энэ 2 яг хуулийн төслөөр татвараас хөнгөлж, чөлөөлж байгаа одоо яг жилд ер нь хэдий хэмжээний яг ийм чөлөөлөлт үүсэх гээд байгаа юм бэ? Ийм дэмжлэг үүсэх гээд байгаа юм бэ?

Дээрээс нь энэ нөгөө нэг юу байгаа шүү дээ, эрчим хүчний энэ үйлдвэрлэх, тэгээд энэ дамжуулах, түгээх, хангах үйлчилгээний ажиллагааны зардлаа нөхөх энэ салбарын өрсөлдөөнд энэ зах зээлийн ер нь энэ тодорхой юу гэдэг юм, ингээд зарчимд шилжүүлэх энэ менежментийг ер нь Эрчим хүчний яам ер нь юу гэж үзэж байгаа юм бэ? Тэгээд тэр би тэр саяын тэр хэн, сайдын хэлж байгаа нүүрсний тийм ээ. Ингээд уурын зуухнуудыг барьж барих боломжтой 1,5 мвт-аас дээш гэдгийг бол үнэхээр ойлгохоо больчихлоо.

Энэ чинь өөрөө бодлогын эсрэг явж байгаа юм биш үү? Агаарын бохирдлын асуудлын. Тэр тал дээр бас юу яая асуулт авъя, юу хариулт авъя.

Тэгээд ер нь энэ эрчим хүчний салбарт шинэ технологи нэвтрүүлэх тал дээр ер нь та нар ер нь яг ямар бодлого баримталж байгаа вэ? Энэ татвараас хөнгөлж, чөлөөлөх байдлаар л одоо юу гэдэг юм, ер нь ингээд төр ингээд өөр дээрээ ачаагаа үүрээд яваад байх юм уу? Ер нь яг энэ менежментээ юу гэж харж байгаа юм бэ? Цаашид.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Өнөрболор гишүүний асуултад тодруулаад хариулъя. Манай салбар хамгийн хүндрэлтэй асуудал нь борлуулалтын үнэ дээрээсээ тохируулгатай. Зардал нь зах зээлийн үнээр гарч байгаагаас шалтгаалаад саяын таны хэлээд байгаа хүндрэлүүд алдагдлууд гараад байгаа юм. Тийм учраас эхний юу зорилго бол эхний ээлжид ядаж бараа бүтээгдэхүүнийхээ өртгөөрөө борлуулагдах ийм шаардлага үүсэж байгаа. Алсын хэтийн зорилго бол мэдээж эрчим хүчний үнээ зах зээлийн үнэд шилжүүлдэг либералчлал бүрэн либералчлалд очих шаардлагатай. Өнгөрсөн жил бас хэлтэй амтай шүүмжлэлтэй дагуулаад нэг удаа нэмсэн. Дахиад нэмэхээс ондоо аргагүй байдалтай ийм байгаа. Байнга л нэмэх ёстой. Уул нь энэ томьёонд оруулаад индексжүүлээд ингээд нэмчих бололцоотой ийм л юу сэдэв л дээ.

Гэхдээ өнгөрсөн 2 жил ковид гээд, энэ дайны нөлөөнөөс шалтгаалаад улс орнууд дээр эдийн засаг аж ахуйн нэгжүүд, иргэд дээр хүндрэлтэй байгаа учраас энэ нэг удаа нэмсэн. Дахиад нэмэхийн тулд иргэд аж ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Хариултыг нь нэмээд өгье. Чойжилсүрэн сайд.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Чойжилсүрэн: Иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлого нэг тогтворжиж эхлээд дараагийн жилээс нь нэмэхгүй бол шууд нэмэхэд найдваргүй олголт үүсэх ийм эрсдэлтэй тулчхаад байгаа учраас ийм бодлого оруулж байгаа юм. Одоо уул нь үнээ нэмчихдэг сэн бол борлуулалтын үнээ орлогоо нэмчихэд гэсэн ийм төрлийн хөнгөлөлтүүд хэрэггүй байхгүй юу. Бид нар аргагүйн эрхэнд ингээж оруулж ирж байгаа юм. Одоо манай эрчим хүчний хэрэглээ жилд 7-8 хувь өсөж байдаг. Шинээр энэ салбар луу хувийн хөрөнгө оруулалт оруулаад ашиг олоод, оруулсан хөрөнгөө оруулаад дараа нь ашиг юу хүртэх тухай ойлголт байхгүй учраас ямар ч байсан энэ 29 он, 30 он гэхэд л шинэ сэргэлтийн бодлогын эхний шалгуур үзүүлэлт 30 онд тохионо. 30 он хүртэл бид нар энэ төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд энэ төслүүд дээр юу Шинэ сэргэлтийн бодлогод туссан төслүүд дээр ийм татварын дэмжлэг үзүүл ээ л гэж байгаа юм. Мөнгөн урсгал дээрээ ялангуяа хүндрэлтэй байгаа.

Дээрээс нь Парисын хэлэлцээр байгаа. Нүүрсний эх үүсвэрт мөн барууны систем мөнгө бол санхүүжилт хийхгүй байгаа. Си Жинь пин дарга 2021 оны намар 9 дүгээр сард байх, НҮБ-ын чуулган дээр Хятадын газар нутгаас гадна нүүрсний эх үүсвэрээр цахилгаан станц барихад санхүүжүүлэхгүй гээд шийдвэр гарчихсан. Ийм санхүүжилтийн хувьд бас аягүй тийм давхар хүндрэлтэй байгаа учраас энэ аж ахуйн нэгжүүдийг энэ энд манай салбарт хөрөнгө оруулж байгаа хүмүүс жоохон дэмжлэг болгох гэж л энэ 2 хуулийн төслийг оруулж ирж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн нэмж тодруулъя.

Д.Өнөрболор: Би үндсэндээ бодлогын арга хэмжээ авч байгаа гэдэг асуудлыг ойлгоод л байна л даа. Гэхдээ энэ нөгөө нэг агаарын бохирдлын эсрэг тийм ээ. 1,5 мянган мвт-аас дээш энэ үндсэн эх үүсвэрийг бий болгож байгаа нэн ялангуяа

энэ бүтээн байгуулалт барилга барьж байгаа аж ахуйн нэгжүүд ч байдаг юм уу тийм ээ, уурын зуухнууд ингээд бариад эхлэх юм бол энэ чинь агаарын бохирдол бүр ерөөсөө арай дэндэнэ биз дээ. Тэгээд энэ дээр ямар нэгэн ийм хязгаарлалттайгаар юу яах нэмэгдүүлэх асуудлыг ярьж болдоггүй юм уу? Уурын зуух гээд тэгэхээр чинь нэг л ойлгомжгүй асуудал үүсээд байна л даа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Өнөрболор гишүүн ээ, бид нар Улаанбаатар хотод ТЭЦ 2, ТЭЦ 3, ТЭЦ 4 нийлээд жилдээ 5 орчим сая тонн нүүрс түлж байгаа. Бас л энэ юу юу ТЭЦ-үүд дээр яндан дээр нь шүүлтүүр тавиад л ажиллуулахаас ондоо арга байхгүй. Бид нар үүнийг бусдыг юу ондоо эх үүсвэрээр юу энергийн эх үүсвэрээр хангаж чадахгүй. Яг үнэндээ тэр газаар бид нар халааж дийлэхгүй, тийм газ байхгүй манайд. Тэгэхээр бид нар хүссэн хүсээгүй нүүрсээ түлэхээс ондоо аргагүй. Харин нүүрснээс ялгарах утааны нэг хэсгийг нь урьдчилж боловсруулаад утааны нэг хэсгийгээ булна гэсэн үг. Түлшээ сайжруулах бодлогууд явж байгаа, үүнээс ондоо арга байхгүй. Түүнээс биш бид нар ийм тийм нэг юу ДНБ-д тийм хангалттай хэмжээнд хүрчхээгүй бид нар баяжаагүй байна, улс. Уурын зуухыг шаардлагатай тохиолдолд барихаас ондоо аргагүй. Гэхдээ тэр шинэ уурын зуухнууд дээр хуучин байгаа уурын зуух шиг одоо байгаад байхгүй, бүх төрлийн юу стандартыг нь нэмэгдүүлнэ. Нүүрсний эх үүсвэрийг түлхээс ондоо аргагүй.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд нэмж тодруулга тайлбар өгье.

Б.Жавхлан: Өнөрболор гишүүний асуултад зүгээр нэмж, мэдээлэл өгье. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт дээрээ бол яг ийм заалт байгаа юм. Энэ цахилгаан эрчим хүчний 5 мвт-аас дээш эсвэл дулааны эрчим хүч гэж байгаа шүү,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

эрчим хүчний, тийм, түүнээс байгаа яг эрчим хүч үйлдвэрлэхгүй. Зүгээр дулааны үйлдвэрлэл дээр бол энэ татварын чөлөөлөлтөд хамрагдахгүй байхгүй юу. Зөвхөн эрчим хүч.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн асуулт асуугаарай. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ дээр бас тодорхойгүй байна. Яг гаалийн албан татвараас ААНОАТ-аас яг алийг нь чөлөөлөх юм, чөлөөлөх юм нь яг аль юм, 1-д.

2-т, хөнгөлөх нь яг хэд юм, хөнгөлнө гэдэг чинь бас өөр, 100 хувь биш, ямрыг нь хөнгөлөөд, ямрыг нь чөлөөлөх гэж байгаа юм бэ гэдгийг нэгд асууя. Ингэснээрээ ер нь цаад энэ хөрөнгө оруулагч нар чинь манайд ийм санал тавиад байгаа юм уу, та бүхэн гааль, ААН-ийн гэдэг юм уу, орлогын албан татвараас хөнгөлж чөлөөлж өгөөч ээ гэж. Тэгэхгүй бол бид нар хөрөнгө оруулалт хийхгүй ээ гээд байгаа юм уу. Эсвэл бид нар хөрөнгө оруулагчдыг урьж энэ салбарын эрчим хүчний эх үүсвэрүүдийг бүрдүүлэхийн тулд ийм хөнгөлөлт, дэмжлэг, урамшуулал үзүүлье гээд байгаа юм уу? Энэ манай талын Монголын талын яг хүлээсэн үүрэг мөн юм уу? Миний санахын 17 онд эхэлж байсан Багануурын 400 мвт-ын ДЦС бол тухайн үед эхэлж байхдаа бол ямар нэгэн хөнгөлөлт урамшууллын асуудал яриагүй аж. Ажлаа эхлээд явж байсан. Одоо заавал ийм хөнгөлөлт урамшуулал нэхээд байгаа юм уу, хүсээд байгаа юм уу гэдгийг 1-д асууя.

2-т, саяын ярьсан энэ Багануурын ДЦС-ын ажил ер нь цаашидаа яахаар байна вэ сайд аа. Одоо өдийд 17 онд эхэлсэн шигээ явсан бол өдийд ашиглалтад ороод үйлдвэрлэл явагдаж байх ёстой гэж би хувьдаа боддог. Харамсалтай нь улс төрийн янз бүрийн шалтаг шалтгаанаар өнөөдрийг хүртэл ингээд гагцхисан. Концесс юм нь тэгээд тэр даргынх нь хэлсэн үгнээс болоод

эрчим хүчний салбарт нүүрсний төсөл, хөтөлбөрийг дэмжихгүй гэдгээс болоод ингээд концесс эзэмшигч нь өөрчлөгдөж байгаа л гэсэн юм яриад байгаа. Тэгээд энэ тал дээр цаашидаа энэ ажил явах юм уу, явахгүй юм уу, явбал хэзээнээс явахаар байгаа юм гэдэг энэ 1, 2 асуултад хариулж өгөөч.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Сандаг-Очир гишүүн ээ, ингэнэ. Дулааны хүчин чадлын хувьд бол 1,5 мвт. Цахилгааны хүчин чадлын хувьд 5 мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэр барьж байгаа бол эсвэл хослон барьж болно шүү дээ. Энэ 2 аль нэгэнтэй нь. Ингэсэн тохиолдолд үндсэн хөрөнгөд бүртгэгдэх импорттоор оруулж ирж байгаа гаалийн албан татварыг бол бүрэн чөлөөлнө. Энэ төслүүд дээр. НӨАТ-ыг нь бол орж ирэхэд нь гааль дээр авдаг байсан шүү дээ. Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар 2 жил хүртэл хойшлуулж болно гээд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд байгаа.

Энэ 2 жилийн хугацаа нь арай богино байна. Одоо бүтээн байгуулалтын үед бол санхүүжилтийн хомсдолтой байгаа учраас 4 жил болгож хойшлуулъя гэсэн ийм хөнгөлөлтийн асуудал орж ирж байгаа.

НӨАТ нь 4 жил хойшилно оо гэсэн үг. Үүнийг ингээд бид нар дандаа импортлоод байж болохгүй шүү дээ. Дотоодын ААН-үүд одоохондоо яг ийм энэний тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг ААН Монголд байхгүй байна. Гэхдээ Монголдоо үйлдвэрлэсэн тохиолдолд ААН-үүдийг дотоодын ААН-үүдийн ААНОАТ-ыг 90 хувь хөнгөлье өө гэсэн ийм урамшуулах ийм 3 харилцааг зохицуулж байгаа. Яг одоо таны ярьж байгаа Багануурын станцын юу хөрөнгө оруулагч нар нь хуучин хөрөнгө оруулагч нар нь дургүйд хүчгүй гэдэг юм болчихсон.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хуучин хөрөнгө оруулагч нар нь гараад явж байгаа. Шинэ хөрөнгө оруулагч нар нь 7 хоногийн өмнө ирж уулзсан. Би бас юу сайдаар томилогдсоны дараа 2 удаа тэр төсөл дээр нь очиж уулзсан. Хятадад ажиллахдаа бас шинэ, хуучин хөрөнгө оруулагч нартай нь уулзсан. Энэ татварын хөнгөлөлт үзүүлчихсэн тохиолдолд магадгүй жижигхэн тэр оруулсан хөрөнгөө нөхөж магадгүй гэсэн ийм төслийн танилцуулгууд явж байгаа юм. Үүн дотор Багануур ч орно, Бөөрөлжүүт ч орно, Тавантолгойн цахилгаан станц ч орно, ТЭЦ 3-ын өргөтгөл ч орно. Ингэхгүй бол энэ хүндрэл нь үнэ дээрээсээ зохицуулалттай, зардал дандаа инфляцаар гардаг, зах зээлээр гаргадгаас шал шалтгаалаад банк эйбл байхгүй байгаа байхгүй юу. Дандаа банк эйбл нот болчихоод байгаа юм. Энэ эрчим хүчний салбар бүгдээрээ. Тэгэхээр 1 үнээ бид нар чөлөөлж чадахгүй байгаа учраас татвар талд нэг жоохон дэмжлэг үзүүлээд энэ өсөн нэмэгдэж байгаа хэрэглээгээ хангая л гэж ийм л одоо аргаа барсан л юм.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн нэмж тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Зүгээр ганцхан богинохон асуулт. Эдийн засгийн тооцооллоор хэдий хэмжээний алдагдал хүлээж байгаа вэ? Хөнгөлөлт алдагдал гэх юм даа, чөлөөлөх асуудлаас болж тийм орлогоо алдаж байна шүү дээ бид нар чинь. Төдий хэмжээний орлого орох ёстой байсан гэж тооцоолбол хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр энэ тооцоо эдийн засгийн тооцоо нь ямар байгаа юм?

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Зүгээр энэ бид нар бол яг энэ төслүүд яг эцэслээд бүгдээрээ явна гэдэг шийдвэр байхгүй байна шүү дээ, 2 гадаад дотоодын хүндрэлүүдээс шалтгаалаад. Зүгээр Тавантолгойн цахилгаан станц дээр бид танд жишээ болгоод юу тооцоолол

өгөхөд 300 мвт-аар 2 блок бариад явахад 550-600 орчим сая доллар болох юм байна. Энэ дотор импортоор оруулж ирж байгаа НӨАТ-ын хэмжээ бол хөнгөлөлтийн хэмжээ 17 орчим сая доллар болно, импортоор. НӨАТ нь зүгээр 4 жилийн хугацаанд хойшлуулах болохоос биш 4 жил хүртэл хугацаанд ямар нэгэн хөнгөлөлт байхгүй, чөлөөлөөгүй, тийм.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Энэ мэдээж Сангийн яам өөрийнх нь харьяа байгууллага Гаалийн ерөнхий газраас энэ саналаа авдаг юм уу. Ер нь бол ингээд яг энэ бараа бүтээгдэхүүний тоног төхөөрөмжийг импортлох түүний татварыг чөлөөлөх тухай асуудал байгаа. Тэгэхээр энэ биткусын код гэж байдаг. Тэр биткусын кодыг нь тодорхой тусгаж өгөхгүй бол энэ нөгөө хэрэгжих явцад ингээд дураараа аашилах ийм зүйл байх байх. Мэдээж одоо юу байдаг юм яг нөгөө 5 мегабатаас дээшээ энэ тэр гээд тэр шаардлагууд дээрээ тодорхой заагаад өгчхөж байгаа. Хамгийн гол нь тэр чинь биткусын кодын 84 дүгээр бүлэг рүү орох уу, 90 лүү орох уу энэ чинь бас яг тэр дулааны цахилгаан үйлдвэрлэл гэдэг чинь тэр дотроо тоног төхөөрөмж дотроо янз янзын код л байгаа л даа. Тэгэхээр энэ кодыгоо ер нь бол цаашидаа Засгийн газар энэ бараа бүтээгдэхүүнийг импортоос импортын татвараас чөлөөлөх тэр асуудал дээр заавал кодыг тавьж оролцож баймаар байна. Тэгэхгүй бол энэ нь бол бас ингээд нэлэнхийдээ асуудлыг ингээд ерөнхий тавьчихдаг. Түүнээсээ болоод дур дураараа нөгөө дунд шатын байгууллагууд асуудалд өөрөөр ханддаг, татвараас зайлсхийх тэр боломжийг нь олгодог, аль эсвэл чөлөөлөх боломжтой байсаар байтал түүнийг нь нугалаа гаргаж болиулдаг иймэрхүү зүйл гараад байдаг байхгүй юу. Тийм учраас энэ дээр энэ гаалийн ерөнхий газар, Сангийн яам энэ дээр ямар байр суурьтай байгаа юм?

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Пүрэвдорж гишүүн ээ, яг таны болгоомжилж байгаа зөв өө. Энэ хуулийн төсөл батлагдсаны дараа Засгийн газраар дахиад холбогдох журам орно. Тэр журам дээр тэр биткус кодууд ороод, ямар ямар ангиллын ямар хөнгөлөлтүүдийг эзлүүлэхийг салаа утгагүйгээр Засгийн газрын тогтоолоор бас батална, 1.

2 дугаарт, энэ хуулийн төслийг боловсруулахдаа Сангийн яам болон гааль татвараас нь саналыг нь авсан. Энэ Гаалийн тарифын тухай хуульд энэ хуулийг дагасан Засгийн газрын тодорхой журмууд байгаа. Гаалийн байцаагч болгон бонд бүр дээр цаг хугацаанд өөрийнхөө тийм юугаар үзэл баримтлал, шийддэг тийм асуудал гарахгүй. Сангийн яам Тэлмүүн чи нэг.

Г.Тэмүүлэн: Тэлмүүн. Номер 5.

Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн Пүрэвдорж энэ асуултад хариулъя. Яг энэ орж ирж байгаа төсөлтэй холбоотой зохицуулалт бол одоогийн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.2-т байдаг. Энэ дээр бол тусгайлсан төслийг Засгийн газар батлаад, Засгийн газар өөрийнхөө баталсан журмын дагуу тухайн импортлогч Сангийн яам тэгээд салбарын яамтайгаа гуравласан гэрээ байгуулаад түүн дээрээ яг төсөлд шаардагдах бараа, тоног төхөөрөмжийнхөө биткусын кодыг нь батлаад хэрэгжүүлээд явдаг. Энэ жишигийн дагуу бол бид нар оруулж байгаа. Өмнө нь таны хэлж байгаатай холбогдуулаад нөгөө урьдчилаад кодоо баталчихдаг дараа нь бол хэрэгжилтээр тодорхой асуудлууд гарах тохиолдол байдаг учраас бид нар энд энэ хуулийн төсөл дээр ингэж оруулсан. Энэ дээр бол яг хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр Гаалийн тариф татварын хуулийн 40.5 дугаар зүйлийн журам Засгийн газар батлахтай холбоотой заалтыг бол нэмж

орүүлж байгаа. Тэгэхээр энэ дээр бол хэрэгжилтээр бид онцгой анхаараад явна.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн нэмж тодруулъя.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль хэлэлцэж байгаа. Дараа нь гааль байгаа шүү тийм ээ.

Гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Кнопоо дараарай. Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах гээд энэ өөрөөр хэлэх юм бол ТЭЦ 3, 4 тийм ээ, энэ Налайх, Багануур гээд энэ нүүрсний дулааны станцуудын асуудал одоо яригдаж байгаа тохиолдолд бол би бас үүнийг ойлгоод байна гэдгийгээ бол хэлээд байгаа. Гэтэл өмнө нь тийм ээ, энэ хотын агаарын бохирдол үнэхээр гамшигт хүрч байсан нэг юу гэдэг юм нэг жишээ нь бол маш их олон уурын станцууд, тийм ээ одоо ингээд ААН-үүд барьж байгуулаад, тэгээд тэрнээсээ салж ангижрах гэж бид нар ёстой нэлээдгүй олон жилийг туулсан. Тэгээд яг энэ зохицуулалтаар бол өнөөдөр зөвхөн төрийн өмчит тийм ээ, энэ компанийн зарчмаар явж байгаа ААН-үүд биш үндсэндээ 1,5 мвт-аас дээш дулааны үндсэн эрчим хүчийг үйлдвэрлэж байгаа энэ уурын цахилгаан станцууд нүүрсний станцууд сая сайд ч гэсэн өөрөө хүлээн зөвшөөрч байна. Тийм ээ, ийм агуулгаараа явах юм бол энэ угаасаа агаарын бохирдол бол гамшиг авчирна. Тийм учраас үүнийг энэ агуулгаар нь би бол дэмжихгүй ээ. Үүнийг бол дэмжиж болохгүй ээ, гишүүд ээ, гэж би бас хэлмээр байна.

Нүүрсээр ажиллах энэ станцын хүчин чадлыг тийм ээ, нэмэгдүүлж ингэж

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бүхэлдээ хотод ингээд тийм ээ, олон төрлөөр нь ингээд байрлуулна гээд тэгэх юм бол үүнийг үнэхээр болохгүй. Тэгж ярих юм бол энэ Парисын гэрээний эсрэг явж байгаа л асуудал шүү дээ, ер нь бол бодлогын түвшин бодлогын асуудал.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд санал хураалтыг явуулъя.
Санал хураалт.

Санал хураалтад 12 гишүүн оролцоноос 7 гишүүн дэмжлээ.

Ингээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батсуурь гишүүн танилцуулчих уу, та.

Батсуурь гишүүн танилцуулна.

Ингээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

09.58 цаг

Дараагийн асуудалдаа орцгооё.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн танилцуулна.

Б.Чойжилсүрэн: Байнгын хорооны дарга, гишүүд ээ. Алсын хараа

2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Шинэ сэргэлтийн бодлогод туссан эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, аймаг, орон нутагт үйлдвэрлэл технологийн парк байгуулах, Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлж ажлын байр бий болгох, цаашилаад хот, суурин газарт шинэ суурьшлын бүсүүдийг бий болгоход эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж, хүчин чадлыг өргөтгөх, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 7-8 хувиар өсөж, эрчим хүчний салбар системийн нийт суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж, импортын эрчим хүчний дэмжлэгтэйгээр өвлийн оргил ачааллыг давж байна. Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 450 мвт хүчин чадал бүхий Тавантолгойн цахилгаан станц, 400 мвт хүчин чадал бүхий Багануурын цахилгаан станц, 300 мвт хүчин чадал бүхий Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг барьж байгуулах мөн Дулааны 3 дугаар цахилгаан станцыг 300 мвт-аар өгөгдөх төслүүдийг төлөвлөсөн.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай 2015 оны Парисын хэлэлцээрийн дагуу олон улсын банк санхүүгийн байгууллагуудаас нүүрсний эрчим хүчний эх үүсвэрт олгох санхүүжилт хумигдсан. Мөн БНХАУ-ын Засгийн газар хилийн чанадад нүүрсний эрчим хүчний шинэ эх үүсвэр барих санхүүжүүлэхээс татгалзах бодлогыг 2021 оны 9 дүгээр сард илэрхийлсэн. Монгол Улсын эрчим хүчний анхдагч нөөц баялагтаа тулгуурлан суурь ачааллын горимд ажиллах том чадлын ДЦС барих зайлшгүй шаардлагатай боловч санхүүгийн эх үүсвэрийн хязгаарлалт олон улсын худалдаа, бизнест тулгарч буй цар тахлын нөлөө,

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үнийн өсөлт зэрэг шалтгааны улмаас эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт татахад хүндрэлтэй болж байна.

Иймд нүүрсээр ажиллах ДЦС барих болон өргөтгөх төслүүдийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд үндсэн тоног төхөөрөмжийг импортоор худалдаж авах болон дотоодод үйлдвэрлэхэд тодорхой хугацаанд татварын дэмжлэг үзүүлэх хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьж байна. Тухайлбал, цахилгаан эрчим хүчний 5 мвт-аас дээш хүчин чадалтай, дулааны эрчим хүчний 1,5 мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэр барих, суурилагдсан хүчин чадлыг өргөтгөх, тухайн шинэ эх үүсвэрийг цахилгаан, дулааны хангамжийн системд холбох шугам болон дагалдах дэд бүтцийн төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн импортын нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эс үгүй бол уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх, эдгээр тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн цахилгаан эрчим хүчний 5мвт-аас дээш хүйтэн чадалтай, дулааны эрчим хүчний 1,5 мвт-аас дээш хүчин чадалтай эх үүсвэрийн үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг 90 хувь хөнгөлөх зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд тусгасан болно.

Эрчим хүчний нэгдсэн систем тогтвортой үйл ажиллагаатай том чадлын станцууд холбогдсоноор сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг холбох техникийн боломж

бурдэж, системийн оновчтой бүтэц бий болгох ач холбогдолтой юм.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх хугацааг цахилгаан станцыг барилга угсралтын ажил үргэлжлэх хугацаатай уялдуулан 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байхаар хуулийн төслүүдэд тусгасан.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайдад баярлалаа.

Та бүхэнд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сангийн сайд Жавхлан, Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлогын төлөвлөлтийн газрын дарга Ерэн-Өлзий, Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга Мөнхжаргал.

Хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Пүрэвдорж, Сандаг-Очир. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр эрчим хүчнийхээ үнэ тарифыг чөлөөлчих юм бол ийм татварын хөнгөлөлт, чөлөөлөлт яриад суухгүй л дээ. Тэгэхээр яг энэ үнэ чөлөөлчих юм бол хувийн хэвшил энэ рүү ороод ирэх ийм боломжийг нээх юм, 1 дүгээрт.

2 дугаарт, өнөөдөр Хятадууд санхүүжилт өгөх боломжгүй гэж яриад суух нь утгагүй асуудал болох юм. Өөрөөр хэлбэл Хятадууд өөрсдөө энэ үнэ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

чөлөөлсөн тохиолдолд бас тодорхой хэмжээгээр энэ салбар луу орж ирж, хөрөнгө оруулалт хийх ийм боломж нь нэмэгдэнэ.

2 дугаарт нь, Атомын цахилгаан станцыг барих асуудал бол манай Монголын хувьд бол хамгийн чухал зүйл болоод байгаа юм. Ойролцоогоор 100 мвт-ын Атомын цахилгаан станц бол нэг ойролцоо 1 тэрбум орчим доллароор баригдах ийм боломжтой. Тэгэхдээ үүнийг бол шийдэх бол амархан. Өөрөөр хэлбэл бид нар бас энэ ураны нөөц ихтэй. Тийм учраас энэ дэлхийн НҮБ-ын байнгын 5 гишүүн орон, тэд нарт бас энэ ураны нөөцийг ашиглуулах замаар энэ бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тодорхой хэмжээний Атомын цахилгаан станцаа бариад явах юм бол бид нар боломж байна. Тэгэхээр энэ Улаанбаатар хотоос нэг жоохон зайтай нэг ганцхан портер машин дээр багтаахаар хэмжээний л ийм л технологи болж хувирсан шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид нар сайн ажиллаж чадах юм бол амжилтад хүрэх ийм боломж байгаа, 2-т.

3 дугаарт нь, энэ би түрүүн бас асуусан, энэ Засгийн газар тодорхой ерөнхий байдлаар энэ бараа бүтээгдэхүүний болон тоног төхөөрөмжийг импортлоход гаалийн болон бусад тэр татвараас чөлөөлөх тухай асуудлыг шийддэг. Тэгээд энэ Засгийн газар дээр эрх аваад тэр Засгийн газар дээрээ энэ асуудлаа өргөжүүлэх ч юм уу иймэрхүү байдлаар шийдэх ийм боломжийг бий болгоод байгаа юм. Тэгэхээр бид нар энэ Улсын Их Хурал бол энэ татвараас чөлөөлөх тэр бүрэн эрхийг өөрсдөө авдаг. Гэтэл үүнийгээ Засгийн газар авчхаад тэр биткусын кодын дагуу оруулж ирээд бүгдийг нь шийдэх боломжтой байтал түүнийгээ шийдэхгүй өргөтгөсөн маягаар Засгийн газар эрхээ авдаг энэ байдлыг бол Төсвийн байнгын хорооны дарга та бас нэг энэ тодорхой харж байгаад үүнийг хуульчлах, өөрөөр хэлбэл заавал энэ чинь биткусын код гэж бүгд одоо бүх бараа

бүтээгдэхүүний жагсаалт байж байгаа. Тэгээд энэ хүрээнд чөлөөлнө гэдэг асуудлаа эхлээд оруулж ирэх ёстой байхгүй юу. Тэгж Их Хурал дээр танилцуулаад тэрнийхээ дагуу чөлөөлөх тухай асуудлыг ярихгүй, ерөнхий 1 бүтээгдэхүүн гэж, тоног төхөөрөмж гэж авчхаад өнөөдрийн байдлаар бол дулааны эрчим хүчний тоног төхөөрөмж гэж авчхаад тэрэнд тэрнийгээ цаашаа Засгийн газар дээрээ энэ Их Хурлын эдлэх эрхийг улам өргөжүүлээд явах ийм боломжийг л энэ асуудлын хүрээнд авч байна шүү дээ.

Тэгэхээр ер нь бол Төсвийн байнгын хороо бид нар бас орлогоо алдах ёсгүй ийм бүтэц. Тийм учраас энэ цаашидаа энэ бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг импортлох тохиолдолд заавал биткусын кодыг нэг бүрчлэн тавиад, түүгээрээ бүх асуудлаа хаагаад явах нь чухал л гэж би үзэж байгаа. Тэгээд энэ дээр бас өөрөө бас Сангийн сайд байсан энэ асуудал дээр бас нэлээн сайн мэдэх байх. Тэгээд цаашидаа бол энэ мэдээж энэ удаа бол эрчим хүчний асуудал ороод ирж байна. Цаашидаа өөр ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Пүрэвдорж гишүүн ээ, би бас яг тантай ижил байр суурьтай анх хуулийн төсөл боловсруулж байхдаа байр суурьтай байсан юм. Тэгээд энэ төслүүд дээр юу төслүүд маань өөрсдөө янз бүрийн санхүүгийн хэрэгсэл гарна. 3 дугаарт, тоног төхөөрөмжүүд маань бас өөрчлөгдөөд байгаа учраас биткусыг бид нар яг заагаад явчихаар магадгүй биткус дахиад нэмэгдэнэ. Төслийн хугацаанд, энэ чинь 29 оныг хүртэл хэрэгжих хугацаатай байхгүй юу. Тэгээд энэ биткус кодыг тавилгүй оруулж ирсэн. Та шаардлагатай гэж үзвэл өнөөдөр хэлэлцэх эсэхээ шийдчихээд, чуулганаар ороод буцаад ирнэ шүү дээ. Байнгын хороо дээр, дэмжсэн тохиолдолд. Анхны хэлэлцүүлгийн үед

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зарчмын зөрөөтэй санал байвал бид нар танд бүх мэдээллээр хангая. Атомын цахилгаан станцын тухайд судалгааны ажил эхлүүлж байгаа.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Эрчим хүчний хэрэглээ ер нь ямар байгаа юм? Бид нарын хүчин чадал ямар байгаа юм? Цаашидаа ойрын үед өсөн нэмэгдэх хэрэгцээ нь ямар байгаа юм? Ийм хэрэгцээ байхад бид нарын хүчин чадал хаана нь яаж дутаад байгаа юм? Хэдий хэмжээгээр дутаад байгаа юм. Энэ ойрын үед хэрэгжүүлэх гээд байгаа сая нэр бүхий энэ томоохон төслүүд хэрэгжсэнээр энэ шаардлагатай байгаа эрчим хүчний хэрэгцээг яаж хангах юм, хангаж чадах юм уу үгүй юү гэдгийг 1-д асууя.

2-т, энэ Багануурын ДЦС гэж би ойлгоод байх юм. Хосолж дан цахилгаан станц юм уу. Би бол хувьдаа дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэнэ гэж ингэж байгаа юм. Та бүхний танилцуулга дээр бол ганцхан Багануурын цахилгаан станц гэсэн байх юм. Бөөрөлжүүт цахилгаан станц 300 мвт. Энэ 2 байршлын хувьд хоорондоо 30 гаруй километрийн зайтай. Түүхий эд нь Багануурын уурхай. Бөөрөлжүүт эрчим хүчээ хааш нь өгөх юм, хэнд өгөх юм, борлуулалт нь хаана байгаа юм. Багануур 400 мвт-аа хааш нь өгөх юм. Үүнийг яаж төлөвлөж байгаа юм. Энэ 2 станц цаг хугацааны хувьд хэзээ ашиглалтад орно гэж тооцоолж байгаа юм. Багануурын уурхай чинь энэ 2 станцын түүхий эдийг яаж хангах юм, хангаж чадах юм уу үгүй юү, түүнийг яаж тооцоолж байгаа юм. Энэ станцуудад хэдий хэмжээний нүүрс хэрэгтэй болох юм. Багануурын уурхай чинь өөрөө техник тоног төхөөрөмжийн 60 хувь нь насжилт дуусчихсан, хүчин чадал нь тулчихсан, дагаад хэрвээ Багануурын ДЦС болоод Бөөрөлжүүтийн станцуудыг ярьж байгаа бол энэ Багануурын түүхий эдээ нийлүүлэх энэ уурхайн асуудлыг давхар хөндөхгүй юм

уу? Энэ уурхай чинь өөрөө өнөөдөр тарифын хувьд төрөөс хараат, хүчин чадлын хувьд тоног төхөөрөмжүүдийн насжилт дуусчихсан 60, 70 хувь гээд ингээд өр авлагын хувьд асар хүнд байгаа. Тэгээд үүнийг ер нь яаж та бүхэн төлөвлөж байгаа юм бэ? Гаргаад эрчим хүчээ хааш нь борлуулна гэж тооцоолж байгаа юм бэ? Цаашилаад одоо энд төлөвлөсөн станцуудын эрчим хүч үйлдвэрлээд эхлэхээр үнэ тариф нь цаашидаа ер нь буурах бололцоо боломж гарах уу гарахгүй юу. Энэ тэр гээд ингээд олон асуудлууд байна л даа. Энэ дээр сайд бас нэг хариулт өгөөч.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Сандагаа гишүүн ээ, яг өнөөдрийн 2023 оны 1 дүгээр сарын байдлаар манай өвлийн оргил ачааллын үеэр хамгийн өндөр чадлын хувьд бол 1465 мвт хүрлээ. Суурилагдсан хүчин чадал маань нүүрсний эх үүсвэрүүд маань 1264 байна. Салхи оруулаад Оросын Холбооны Улсаас импортлоод энэ өвлийг давсан. Бид нар 12 жилээр 2035 он хүртэл хэрэглээний өсөлтийн таамаглал таазыг хийж үзсэн. Одоо байгаа энэ хэрэглээ маань 2600 орчим мегаватт болох юм байна. Тэгэхээр миний сая дурдсан ТЭЦ 3-ын өргөтгөл, Багануур, Бөөрөлжүүт, Тавантолгойн цахилгаан станцуудыг орсон тохиолдолд бид нар нэг нөөц хэрэглээнээсээ давсан 200-300 мвт-ын нөөцтэй болж эхлэх ийм тооцоо гарч байгаа.

Бөөрөлжүүтийн цахилгаан станц өөрийн ордтой юм байна. Цэцэнс майнинг гэдэг компани Багануураас авахгүй. Энэ Бөөрөлжүүтийн станцыг бид нар 1 талдаа Баганууртай холбож байгаа, Багануур дэд станцтай. 2 дахь нь одоо бид нар юу дараагийнх нь юу хэлэлцээрийг нь хийгээд Сэргэлэн сум руу Сэргэлэн дэд станцтай холбож байгаа Бөөрөлжүүтийг. Ингээд Сэргэлэн дэд станцаас Сонгино дэд станц руу бид нар

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

220 квт-ын шугам тавиад эхэлчихсэн. Ингээд бүтэн хэлхээ үүснэ.

Багануурын цахилгаан станцын тухайд бол Багануур дэд станцаа шууд эхний ээлжид холбогдоно. Мэдээж Багануураас шууд Сонгинотой холбогдож байгаа. Урагшаа Чойр, Сайншианд, Цагаан суварга, Оюутолгойг энэ шугам холбогдож байгаа. Европын сэргээн босголтын банкнаас Чойр юу 2-ыг нь шийдэж байгаа. Чойроос Шандыг шийдэж байгаа. Азийн хөгжлийн банкнаас бол Багануураас Чойр хүртэл шугамыг шийдсэн. Одоо бид нар Европын сэргээн босголт хөгжилтийн банктэй нэг төсөл яриад явж байгаа нь Сайншиандаас Цагаан суваргын хооронд 220 квт-ын хос шугам барихаар ийм асуудал үүсэх юм. Тэгсэн тохиолдолд бид нар Оюутолгойг дотоодоосоо бүрэн хангаж чадна гэсэн үг. Ийм нөхцөл байдал үүсэж байгаа гэсэн үг.

Багануурын уурхайн тухайд нөхцөл байдал хүнд байгааг та мэдэж байгаа. Та бид нар цуг очиж байсан. Багануурын цахилгаан станц жилдээ 400 мвт гээд ингэх юм бол 1,2 сая тонн нүүрс хэрэглэнэ, жилдээ, хослохгүй. Зөвхөн цахилгаан станц, цахилгаан станц тийм төсөл юм байна лээ. Тэгээд 1,2 сая тонныг энэ станц руу яахын тулд Багануурын уурхай дээр тодорхой хэмжээний өргөтгөл хийнэ, үнийг тохирно одоо. Дөнгөж сая 7 хоногийн өмнө шинэ хөрөнгө оруулагч нараа манай ЭХЯ-тай ажлын хэсэг байгуулаад явж байна. Энэ дотор Багануурын уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлье, үнийг тогтворжуулах валютаар тогтох 20, 30 жилийн хугацаанд, энэ ажлууд хийгдээд явж байгаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу, Сандаг-очир гишүүн.

Би зүгээр нэг зүйлийг нэг тодруулж асууя. Яах вэ, эрчим хүчний салбар дээр бид нар энэ гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, дотоодын

хөрөнгө оруулалтаа дэмжих үүднээс тодорхой энэ татварын бодлогыг бас Засгийн газраас оруулж ирж байна гэж хараад байгаа юм. Энд хөрөнгө оруулалтын гэрээт ААН-үүд бас байгаа байх. Тэгэхээр яах вэ, зүгээр хуулийн үйлчлэл маань яах вэ, батлагдсан өдрөөсөө хэрэгжээд эхлэх байх. Энэ хуулийг 29 оны 12 дугаар сарын 31 хүртэл буюу 2030 он хүртэл үйлчлэхээр байгаад байгаа юм. Тэгэхээр 1 талдаа татварын ийм таатай орчныг бид нар эдлэх боломжийг нь олгож байна л даа. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын гэрээтэй болоод тогтворжуулах гэрээтэй гэрчилгээ авчихсан энэ ААН-үүдэд нэг талдаа үйлчлээд энэ маань энэ тухайн тэр татвар болоод хувь хэмжээнүүд нь тогтворжих энэ таатай нөхцөл байдлыг эдлэх боломжийг олгож байна л гэсэн үг л дээ. Тэгэхээр яах вэ, дахиад нөгөө хөрөнгө оруулалтынхаа гэрээгээрээ 30 оноосоо цаашаагаа тогтворжуулах тэр эрсдэлийг үүсгэх вий дээ гэсэн болгоомжлол бас байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр Засгийн газрын зүгээр бас анхаарч ажиллаарай л гэсэн би зүйлийг хэлэх гээд байгаа юм. Та бүхэн бас мэдээж тодорхой зохицуулалтыг хийж, үүнийг хязгаарлах боломж бололцоо байх болов уу л гэж хараад байгаа юм. Энэ дээр бас анхаараарай.

Гишүүд үг хэлж, асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Санал хураалт явуулъя.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

10 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 80 хувиар дэмжлээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хуулийн төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баделхан гишүүн, та нэгдсэн чуулганд танилцуулах уу? Баделхан гишүүн танилцуулна.

Ингээд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Ажлын хэсэг болоод Байнгын хорооныхоо гишүүддээ баярлалаа.

Байнгын хорооны хуралдаан хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ